



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/151

Улаанбаатар хот

Ж.Оюунтуяаг Ёс зүйн дэд хорооны
гишүүнээр нөхөн томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.1.1, 13 дугаар зүйлийн 13.2 дэх хэсэг, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.7, 2.8, 2.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргаа, удирдлагын газраас зохион байгуулсан санал асуулгын дүнгээр албан хаагчдын олонхын дэмжлэг авсан Иргэний харьяаллын газрын судалгаа, шинжилгээ хариуцсан мэргэжилтэн Жигжидсүрэнгийн Оюунтуяаг 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнээр нөхөн томилсугай.

2.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангах чиглэлээр санаачилгатай ажиллахыг байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүн (Ж.Оюунтуяа), хяналт тавьж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Н.Дуламсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-т даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР